

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХИЙСЭН
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны 82 дугаар захирамжаар Монгол Улсын 2022 оны төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгээс төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд 6 чиглэлээр ажлын дэд хэсгийг байгуулан ажиллуулж, ажлын дэд хэсгүүдээс бэлтгэсэн саналуудыг нэг бүрчлэн хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутагт олгох хуваарилалт болон Ирээдүйн өв сангаас хүүхдийн мөнгийг олгохтой холбоотой харилцааг зохицуулсан хуулийн төслийг өргөн мэдүүлсэн байна.

1.Орон нутгийн төсвийн харилцаанд орсон өөрчлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтын тооцоололтой танилцаж, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгээс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрээс орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн төсөвт олгох хуваарилалтыг шинэчилж, Төсвийн тухай хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 20 хувийг, 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 30 хувийг тус тус тухайн орлогын 1 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймгуудад хуваарилахаар төсөлд холбогдох өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж

үзэж санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Дээрх өөрчлөлтийг тусгаснаар Засгийн газрын өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс аймгуудад хуваарилах хуваарилалтад холбогдох өөрчлөлт орохоор байна.

2. Ирээдүйн өв сангийн эх үүсвэр, хөрөнгийг зарцуулах асуудлыг судлах, санал бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгээс хүүхдийн мөнгийг ирээдүйн өв сангаас жил бүр санхүүжүүлэх нь сөрөг үр дагавартай тул зөвхөн 2022 оны төсвийн жилд нэг удаа ирээдүйн өв сангаас хүүхдийн мөнгийг санхүүжүүлэх, 2022 оны төсвийн жилд ирээдүйн өв сангийн өөрийн дансанд төрийн санд нь хадгалах, мөн Төсвийн тухай хуульд тусгагдсан Ирээдүйн өв сангийн төсвийг тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолтыг 2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болгож, бусад өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөх зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР